

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДТАЙ БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.АМАРСАНААГИЙН
БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

2009 он

Баянхонгор

БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО			
Хяналтад авсан нийт тоо		9	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			
Үүнээс	Биелсэн	7	
	Хэрэгжих шатанд	2	
	Үүний дотор	90%	2
		70%	х
		50%	х
		30%	х
		10%	х
	Тасарсан	х	
Дүн: Хэрэгжилтийн дундаж хувь: 97,7%			

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ХЯНАСАН:

Д.АМАРСАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДТАЙ БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.АМАРСАНААГИЙН
БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2009.07.23.

Баянхонгор

Д/ Д	Батламжийн заалт	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн тайлан, үр дүн, хэрэгжилтийн хувь
1	1.Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	<p><u>1.1.Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж ажилласан байх</u></p>	<p>Засаг дарга миний бие мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2009-2012/, аймгийн хөгжлийн хөтөлбөр болон аймгийн 43,1 мянга гаруй сонгогчдын итгэлийг хүлээж, төрийг төлөөлөн аймгийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийн тойрогтоо хийхээр мөрийн хөтөлбөртөө тусгасан зорилтууд, өмнө нь хэрэгжиж байсан арга хэмжээнүүдийг илүү үр дүнтэй хүргэх ажилтай нягт уялдуулж боловсруулан баталгаажуулан хэрэгжүүлж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын зөвлөлийг олон намын төлөөлөл оруулан бүрдүүлэн ажилласан нь аймгийн Засаг даргаас гаргаж буй шийдвэрийг олон талаас нь олон ургальч үзлээр шүүн хэлэлцэж гаргаснаар хэрэгжих үндэслэлтэй, илүү үр дүнд хүрэх ач холбогдолтой болох нь харагдаж байна.</p> <p align="right">/Хэрэгжилт -100%/</p>
		<p><u>1.2.Засгийн газрын 2009 оны 01-р тогтоолоор батлагдсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хариуцуулсан ажлыг бүрэн хангаж зохион байгуулсан байх</u></p>	<p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан 91 заалтыг хяналтандаа авч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Хэрэгжилт дөрвөн жилийн хэрэгжилтийн дундаж хувь 30,9 хувьтай байна.</p> <p align="right">/Хэрэгжилт-100%/</p>
2	2. Төр засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чанд сахиж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.	<p><u>2.1.Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын хууль тогтоомжийн лавлагааны санг бүрэн бүрдүүлж аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагын захирамж тушаал, бодлого шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хангахад ашигладаг болгох нөхцлийг бүрдүүлэх</u></p>	<p>Засгийн газрын 2004 оны 11 дүгээр тогтоолыг үндэслэн бүх шатны Засаг дарга нарт “Төрийн мэдээлэл” эмхтгэлийг захиалж өгч байх үүргийг сумдын Засаг дарга нарын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгаж хэрэгжилтийг дүгнэн ажиллаж жилийн эцсийн байдлаар аймгийн 100 баг, 20 сумын ЗДТГазар тус бүр хууль зүйн мэдээллийн лавлагааны сантай болж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p align="right">/Хэрэгжилт -100%/</p>
		<p><u>2.2.Аймгийн Засаг даргын захирамжийг хууль тогтоомжийн зүйл заалтад нийцүүлэн эрх зүйн зөрчилгүй гаргасан байх</u></p>	<p>Аймгийн Засаг дарга 2009 онд 519 захирамжийг хууль тогтоомжийн дагуу эрх зүйн зөрчилгүй гарсан.</p> <p align="right">/Хэрэгжилт -100%/</p>

		2.3.Сумын Засаг даргын захирамжийн эрх зүйн үндэслэлийг хянаж зөрчилтэй шийдвэрийг хууль тогтоомжийн зүйл заалтад нийцүүлэн гаргуулж байх	Аймгийн 20 сумын нийт 1656 захирамжийг хянахад зөрчилтэй захирамж 74 байснаас 73 захирамжийн зөрчлийг сумдын Засаг даргын захирамжаар , 1 захирамжийг аймгийн Засаг даргын захирамжаар хүчингүй болгуулсан. /Хэрэгжилт -100%/
3	3.Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар шуурхай үйлчилнэ.	3.1. Нутгийн захиргааны байгууллагыг төрийн мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлсэн байх	Сумдын менежерүүдийг мэргэшүүлэх зорилгоор манлайллын сургалтыг үйлдэн суралцах зарчим, оролцооны аргаар зохион байгуулав. Сургалтад хамрагдсан менежер, удирдах ажилтанууд орчин үеийн менежмент болон манлайллын талаар суурь ойлголттой болж байгууллагын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид хэрхэн яаж ажиллах байгууллага, хамт олон, өөрийгөө хэрхэн яаж хөгжүүлэх “Суралцагч байгууллага” болох зорилт тавин ажиллаж байна. Нийт хамрагдах 160-аад менежерийн 109 нь хамрагдан хөдөөд 25, төвд 25 менежер үлдээд байна. Мөн сургалтад хамрагдсан менежерүүдтэй харилцаатай эргэх холбоотой ажиллаж 2 удаагийн уулзалтыг зохион байгуулав. /Хэрэгжилт -100%/
		3.2.Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар үйлчилэх талаар хийсэн ажлын үр дүнгээр	Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тогтоол 94,3 хувийн хэрэгжилттэй байна. /Хэрэгжилт -100%/
4	4. Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авилга, хээл хахуулийг цээрлэн ажиллана.	4.1.Төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр биелүүлсэн байх	Татварын орлогын төлөвлөгөө 2 465 011,9 мянган төгрөг орохоос 2 725 443,5 мянган төгрөг орж 110,6 хувьтай, төвлөрсөн төсөвт төвлөрөх орлого 315 515,6 мянган төгрөг орохоос 293 873,6 мянган төгрөг орж төлөвлөөний биелэлт 93,1 хувьтай байна. Харин орон нутгийн орлогын төлөвлөгөө 2123367,3 мянган төгрөг орохоос 2399618,3 мянган төгрөг орж төлөвлөгөөний биелэлт 113 хувьтай байна. /Хэрэгжилт -100%/
		4.2.Төсвийг төлөвлөсөн зардлын дагуу зарцуулсан байх	- 2009 оны жилийн эцсийн байдлаар гэрээт улсын төсвийн байгууллагуудын зарлага, санхүүжилт 20212,7 сая төгрөг болж, гэрээт байгууллагууд улсын төсвийн санхүүжилтийг гүйцэд авч төлөвлөсөн зардлын дагуу зарцуулсан байна. /Хэрэгжилт 100%/
		4.4.Төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийх шалгалтыг тогтмолжуулж, шалгалтаар илэрсэн зөрчлийг барагдуулсан байх	- Санхүүгийн хяналт шалгалтын 6 улсын байцаагч 2009 онд 143 төсвийн байгууллагын 2006, 2007, 2008 оны санхүүгийн баримтанд иж бүрэн хяналт шалгалтыг хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр 156 төсөвт байгууллагын 907 хүнийг хамарсан санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулж 293.2 сая төгрөгийн зөрчил илэрж үүнээс 25% буюу 72.8 сая төгрөг нь орон нутгийн төсөвт, 40% буюу 117.7 сая төгрөгийг тухайн байгууллагад нь төлөгдөхөөр төлбөр тавигдаж, 35% буюу 102.6 сая төгрөгийн актыг хуулийн байгууллагад шилжүүлж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын зөвлөлийн хурлаар 7.0 сая төгрөгийн зөрчил чөлөөлсөн. 2009 оны

			<p>бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гүйцэтгэлийн хувь 127% буюу 27%-иар давуулан биелүүлсэн байна.</p> <p>Ажлын хариуцлага алдсан 26 хүнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, НББ-ийн тухай хуулийн дагуу 960.0 мянган төгрөгийн шийтгэвэрийн арга хэмжээ авлаа. 2009 оны 12-р сарын 01-ны байдлаар шалгалтаар илэрсэн актын төлбөрийн биелэлт 92.7%-тай байна</p> <p>/Хэрэгжих шатандаа-100%/</p>
5	5. аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ, соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллана.	<p>5.1.Нийгмийн салбарыг хөгжүүлэх талаар Засаг даргын Хөтөлбөр дэвшүүлсэн зорилт, тухайн жилийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангах арга хэмжээг авсан байх</p>	<p>Нийгмийн салбарын хүрээнд бодлогын 54 захирамж, 4 хөтөлбөр, 3 ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тус салбарын удирдлагуудтай үр дүнгийн гэрээ байгуулан хэрэгжилтийг тооцон ажилласан. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 3 хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, ИТХуралд “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжилтэй ажиллах хүчинг бэлтгэх, хөгжүүлэх” хөтөлбөрийг боловсруулан хэлэлцүүлж батлуулсан. Эрүүл мэндийн газар, боловсрол соёлын газрын даргын сонсголыг Засаг даргын зөвлөлөөр авч хэлэлцэж, тодорхой үүрэг даалгаврыг өгсөн.</p> <p>Нийгмийн салбарыг хөгжүүлэх жилийн зорилтын хэрэгжилт 97.6% байна.</p> <p>/Хэрэгжих шатандаа 100 %/</p>
		<p>5.2.Ажилгүйдэл ядуурлыг бодитой бууруулсан байх</p>	<p>2009 онд шинээр 1999 ажлын байр бий болгосны 1224 нь байнгын, 775 нь түр ажлын байраар хангасан. Мэргэжил олгох сургалтад 332 хүнийг хамруулсаны 256 нь ажлын байртай ба аж ахуй эрхлэх сургалт, арга хэмжээнд 750 хүнийг, эмзэг бүлгийн 833 хүнийг нийтийг хамарсан ажилд оролцуулан амьжиргааг дэмжсэн. Жижиг зээлд 104 хүнд 128.5 сая төгрөгийн зээл олгосноор 198 хүнийг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж 52 төсөлд 864.0 сая төгрөг олгож, 519 хүнийг ажлын байртай болгосон. Ядуурлыг бууруулах зорилгоор сум бүр 20 өрхийг ядуурлаас гаргах үүрэг даалгавар авч аймгийн хэмжээний 470 өрхийн мэдээллийн санг байгуулан, ногоон ажлын байр, нэг өрх- нэг ажлын байр, жижиг зээл, нийтийг хамарсан ажил, олон нийтийн оролцоонд тулгуурласан үйлчилгээ, АДРА, Дэлхийн зөн-Баянхонгор ОНХХ зэрэг хөтөлбөрүүдэд хамруулан амьжиргааг дэмжиж 288 өрхийг ядуурлаас гаргаж, 131 өрхийн амьжиргаа дээшилсэн. Гэвч эдийн засгийн хямралаас шалтгаалж, ажилгүйдлийн түвшин 7.6 ядуурлын түвшин 42.2 болсон.</p> <p>/Хэрэгжилт 90 %/</p>
6	6. Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, гэмт хэрэг, архи дан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга хариуцлагыг өндөржүүлж ажиллана.	<p>6.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах ажилд онцгой анхаарч, цагдаа-олон нийтийн оролцоог сайжруулах”</p>	<p>Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зорилгоор 2009 онд аймгийн хэмжээнд зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу сургалт, сурталчилгааг зохион байгуулж төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 6 удаа төлөвлөгөөт сургалт хийж 506 хүн, 22 сум байгууллагад 18 удаа захиалгат сургалт хийж 583 хүн тус тус хамрагдав. Нийт 46 төрлийн сэдвээр 29 удаа 10053 ширхэг хялбаршуулсан гарын авлага бэлтгэж түгээлээ.</p> <p>/Хэрэгжилт -100%/</p>
		<p>6.2. Архидан согтуурахтай бүх</p>	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи дан согтуурахтай тэмцэх</p>

		<p>нийтээр тууштай тэмцэж үр дүн гаргах”</p>	<p>ажлыг бүх шатанд өрнүүлж, бодитой ахиц өөрчлөлт гаргаж ажиллах зорилгоор архидан согтуурахтай тэмцэх ажлыг үлгэр жишээ зохион байгуулж байгаа “Жишиг сум” болох болзлыг аймгийн Засаг даргын 2009 оны 111 дүгээр захирамжаар батламжлуулан сумдад хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажиллаа.</p> <p>Аймгийн Засаг даргын 2008 оны 92 дугаар захирамжаар батлагдсан “Архидан согтуурагчгүй овог, удам шалгаруулах журам”, “Согтууруулах ундааг гар дээрээс болон зөвшөөрөлгүй цэгээс худалдаж байгаа талаар иргэдээс мэдээлэл авах, шалгах, урамшуулал олгох журам”-ууд тус тус хэрэгжиж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт -90%/</p>
		<p>6.3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах ажлыг сайжруулах”</p>	<p>Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсний дүнд 2008 онд гэмт хэргийн илрүүлэлт 30,3 хувь байсныг 2009 онд 52,7 хувь хүргэж өсгөсөн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт – 90%/</p>
7	7. Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцаа авч ажиллана.	<p>7.1.Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан мэдээг улирал тутам мэдээлж байх</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-ын дагуу тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, явц, үр дүнг тооцон хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, улирал бүр мэдээлж хэвшсэн.</p> <p>Мөн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, биелэлтийн тайланг зөв, оновчтой тодорхойлж байх талаар 4 зөвлөмжийг албан бичгээр өгч, аймгийн Засаг даргын албан даалгавар 1 гаргаж ажиллаа.</p> <p style="text-align: right;">/Биелэсэн 100%/</p>
		<p>7.2.Засгийн газрын бусад шийдвэр, Ерөнхий сайд, Шадар сайдаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, явц үр дүнг тогтмол мэдээлж байх</p>	<p>Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд, Шадар сайдаас тогтоолоор өгөгдсөн үүргийг нийт 45 албан бичиг, тушаал, тогтоол ирүүлснийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт -100%/</p>
		<p>7.3.Засгийн газарт явуулах 10 хоногийн болон сарын шуурхай мэдээллийг тогтоосон графикийн дагуу гарган хүргүүлж байх</p>	<p>Сарын шуурхай мэдээг хугацаанд нь боловсруулж Тамгын газрын даргаар хянуулж баталгаажуулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын onzhyh@prime.pmis.gov.mn, сайтад сар бүр, хагас жилийн байдлаар 12 удаа хугацаанд нь байршуулж ажиллаа.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт – 100%/</p>
		<p>7.4.Засгийн газарт шаардлагатай тулгамдсан асуудал дээр санал боловсруулан тавьж шийдвэрлүүлж дэмжлэг туслалцааг авч ажиллах</p>	<p>Баянхонгор сумын шинээр бий болсон гудамж, хашаа болон бусад цахилгаан эх үүсвэргүй хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам сүлжээ барьж байгуулах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн асуудлыг Засгийн газарт тавиад байна.</p> <p style="text-align: right;">/Биелэсэн -100%/</p>
8	8. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн,	<p>Дээрх дутагдал зөрчлийг гаргалгүй ажилласан байх</p>	<p>Эхний хагас жилийн байдлаар дээрх дутагдал зөрчлийг гаргалгүй ажиллаж байна.</p>

	мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авлига, хээл хахуульд холбогдсон, ёс суртахууны доголдол гаргасан, архи дан согтуурсан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээнэ. Хариуцлага алдаж албан тушаалаасаа чөлөөлөгдөх асуудал нь улс төрийн намын хаацайллыг эрэлхийлэх шалтгаан болохгүй.		/Хэрэгжилт -100%/
9	9. Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг жил тутам Засгийн газарт тайлагнана. Дундаж хувь	<i>Батламжийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гаргаж Засгийн газарт тайлагнаж хэвшинэ</i>	Батламжийг хагас бүтэн жилээр гаргаж хэвшсэн. /Хэрэгжилт 100%/

Тайлбар: 1. Батламжийн хэрэгжилтийн дундаж нь тухайн жилийн зорилтоор 97,7 хувьтай байна.
2. Батламжийн заалтуудад шалгуур, үзүүлэлтийг тогтоон үнэлгээг бодитой хийх зорилгоор гаргалаа.

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ХЯНАСАН:

Д.АМАРСАНАА